



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-47-22-ШТА-СА

Хэрлэн сум 2021 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 70562147 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор Ц.Нарангэрэл

Утас: 70562147 Цахим хаяг: narangerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

	АГУУЛГА
Аудитыг бэлтгэсэн:	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ХАВСРАЛТ ЖАГСААЛТ АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА
Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар	АУДИТЫН ДҮН: СОНГУУЛИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, БҮРТГЭЛД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.
Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар	БҮЛЭГ 1: МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРАМ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА.
Аудитын менежер Д.Оюунтуяа	1.1 МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг СЕХ төлөвлөсөн байна. 1.2 МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсвийг холбогдох чиглэл, тооцооллын дагуу хуваарилсан байна.
Аудитор Ц.Нарангэрэл Ц.Хатанболд Х.Еркегүл Б.Ариунаа Г.Энх-Амгалан	БҮЛЭГ 2: МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛААС 3.6 САЯ ТӨГРӨГИЙГ ХЭМНЭХ БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ БАЙНА.
2021 он 07 дугаар сар	2.1 Сонгуулийн хороо нь УИХ болон ОН-ийн сонгуулиар авсан далбааг Ерөнхийлөгчийн сонгуулиар дахин ашиглаж 3.6 сая төгрөг хэмнэх боломжийг ашиглаагүй байна. 2.2 Батлагдсан төсвөөс 0.2 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн тайлагнасан байна. 2.3 Засгийн газрын нөөц сангаас 39.0 сая төгрөгийн халдваргүйтгэлийн хэрэгсэл олгосон байна. 2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.
Холбоо барих: Утас 7056-2112	
Цахим хаяг khentii@audit.gov.mn	АУДИТЫН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ
Байршил Хэнтий аймаг Хэрлэн сум Чингис хот	Аудитын дүгнэлт
Хэнтий аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 321	Аудитын зөвлөмж
ТООТ	АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ
	Тайлангийн төсөлд ирүүлсэн санал ба тайлбар
	Тайланг баталгаажуулсан шийдвэр

Хавсралт маягтын жагсаалт	
Хавсралт №1	МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан Хэнтий аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл
Хавсралт №2	МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан Хэнтий аймгийн сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа
Хавсралт №3	Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн зардлын тайлан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8¹, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 4.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Хэнтий аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3²-т заасныг баримтлан гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитаар аймгийн Хэнтий аймгийн Сонгуулийн хороо, 19 сумдын сонгуулийн хороо, 89 хэсгийн хороо, МУЗГ-ын нөөц сангаас олгосон хөрөнгийн зарцуулалт зэргийг хамруулан шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхэдээ АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль

¹ Хуулийн 9.8-д Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын дээд байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Хуулийн 6.3. Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар удирдаж, аудитын менежер Д.Оюунтуяа үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ц.Нарангэрэл ахлан, аудитор Ц.Хатанболд, Х.Еркегүл, Б.Ариунаа, Г.Энх-Амгалан нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2021 оны 06 дугаар сарын 16-наас гүйцэтгэж, аудитын тайлангийн төслийг 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр дотор дарга, Тэргүүлэх аудиторт танилцуулж, аудитын тайланг 2021 оны 07 дугаар сарын 05-ны дотор Үндэсний Аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлнэ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шинэчлэн баталж, 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс дагаж мөрдсөн байна.

Энэ хуулийн дагуу зохион байгуулагдах Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг аймгийн хэмжээнд зохион байгуулах сонгуулийн хороог МУ-ын СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 40 тоот “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо байгуулах тухай” тогтоолоор Хэнтий аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Үүнд: Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүдтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн аймгийн сонгуулийн хороонд 9 албан хаагч, 18 сумын сонгуулийн хороонд 94 албан хаагч, 89 хэсгийн хороонд 645 албан хаагч, аймгийн сонгуулийн хорооны дэргэдэх мэдээллийн технологийн багт 5 албан хаагч, сумдын мэдээлэл технологийн даамлаар 108 албан хаагч, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 89 төрийн албан хаагч, нийт 950 төрийн албан хаагчид ажиллажээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд Хэнтий аймагт санал өгөх сонгогчийн нэрсийн жагсаалтад 50,120 сонгогч бүртгэгдсэнээс санал хураалтад нийт 31,938 сонгогч буюу иргэдийн 63.72 хувь нь саналаа өгсөн байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо батлагдсан төсвөөс сумын хэсгийн хороодод 435.7 сая төгрөг хуваарилж, дансыг төрийн санд байршуулж, гүйцэтгэлээр 433.1 сая төгрөгийг зарцуулж, 2.6 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд 588.5 сая төгрөгийг хуваарилан баталжээ.

СЕХ-оос Хэнтий аймагт хуваарилсан санхүүжилтээс аймгийн Сонгуулийн хороонд 55.4 сая төгрөг, сумын хэсгийн хороодод 533.1 сая төгрөг хуваарилж, дансыг төрийн санд байршуулж, гүйцэтгэлээр аймгийн Сонгуулийн хороо 50.2 сая төгрөг, сумын хэсгийн хороод 530.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7.9 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Хэнтий аймагт МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой

байдлын Ерөнхий газраас 39.0 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгслийг олгосон байна.

Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/176 дугаар “МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” тушаалаар МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардалд Хэнтий аймгийн УБХэлтэст 76.7 сая төгрөгийг сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, цахим хуудаст байрлуулах, сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах, санал авах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах, албан хаагчийн сургалт зохион байгуулах, томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардлыг тусгаж баталсан байна.

График №1 /сая төгрөг/



Цагдаагийн Ерөнхий газраас МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбоотой хэв журмын хамгаалалтын зардалд Хэнтий аймгийн Цагдаагийн газарт 15.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс хамгаалалтад ажилласан албан хаагчдын хоолны зардалд 9.3 сая, нөөцөд ажиллах албан хаагчдын хоолны зардалд 2.0 сая, шуудан холбооны зардалд 3.2 сая, шатахууны зардалд 1.0 сая төгрөгийг хуваарилсан байна.

График №2 /хувиар/



БҮЛЭГ 1: МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРАМ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1 МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг СЕХ төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”, “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулиудыг үндэслэн 2021 оны ээлжит МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах зардлыг СЕХороо төлөвлөн 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 3/71 тоот албан бичгээр “Аймаг, нийслэл, сум, дүүргийн

сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар"-аар сонгуулийн хорооны зардлын санхүүжилтийн 1 дүгээр хэсэг, 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3/103 тоот албан бичгээр сонгуулийн хорооны зардлын санхүүжилтийн 2 дугаар хэсэг, 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/124 тоот албан бичгээр сонгуулийн хорооны зардлын санхүүжилтийн 3 дугаар хэсгийг төлөвлөж ирүүлсэн байна.

1.2 МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсвийг холбогдох чиглэл, тооцооллын дагуу хуваарилсан байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах сумдын сонгуулийн хорооны санхүүжилтийг олгохдоо СЕХ-оос өгсөн чиглэл, тооцооллыг баримтлан хуваарилсан байна.

Улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт 588.5 сая төгрөгийн санхүүжилт олгосноос аймгийн Сонгуулийн хороонд 55.4 сая төгрөг, сумдын Сонгуулийн хороодод 533.1 сая төгрөгийг дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт №1 /мянган төгрөг/

№	Зардлын нэр	УТ-өөс хуваарилсан төсөв	Нийт зардалд эзлэх хувь	Аймгийн СХ-ноос хуваарилсан		
				сумын СХ-нд	аймгийн СХ-нд	
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	250.0	0.0	-	250.0	
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	19,018.0	3.2	5,526.5	13,491.5	
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарсан зардал	Сургалтын зардал	16,080.0	2.7	9,160.0	6,920.0
		Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	4,005.0	0.7	3,420.0	585.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	5,300.0	0.9	3,135.0	2,165.0	
5	Санал авах байр тохижуулах зардал	28,480.0	4.8	22,695.0	5,785.0	
6	Сургалт, сурталчилгааны зардал	5,000.0	0.8	-	5,000.0	
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	409,580.0	69.6	400,910.0	8,670.0	
8	Бичиг хэргийн зардал	14,010.0	2.4	13,560.0	450.0	
9	Шуудан холбооны зардал	17,050.0	2.9	16,050.0	1,000.0	
10	Унааны зардал	52,550.0	8.9	50,800.0	1,750.0	
11	Албан томилолтын зардал	5,482.0	0.9	4,077.7	1,404.3	
12	Болзошгүй зардал	11,752.0	2.0	3,779.9	7,972.1	
Нийт дүн		588,557.0	100%	533,114.1	55,442.9	
Эзлэх хувь				90.6%	9.4%	

Хүснэгтээс харахад нийт зардлын 90.6 хувийг сумдын Сонгуулийн хороо, 9.4 хувийг аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар тус тус хуваарилсан байна. Улсын төсвөөс хуваарилсан нийт төсвийн дүнд зардлын эдийн засгийн ангиллаар эзлэх хувь хэмжээг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №3 /хувиар/



Үүнээс урамшуулал, хоолны зардалд 409.6 сая төгрөг буюу 69.6 хувь, томилолт, унаа, сургалт, сурталчилгааны зардалд 106.7 сая төгрөг буюу 18.1 хувь, үлдэх 12.3 хувийг бусад зардлуудад хуваарилсан байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит 2017 онтой 2021 оны сонгуулийн санал өгөх насны иргэд, сонгуулийн хороод, ажиллах хүний тоо, төсвийн ерөнхий тоон мэдээллийн төлөвлөсөн дүнг харьцуулахад:

Хүснэгт №2 /тоо, сая төгрөг/

№	Үндсэн үзүүлэлт	Ерөнхийлөгчийн сонгууль		Зөрүү
		2017 он	2021 он	
1	Сонгуулийн насны хүний тоо	47,366	50,120	(2,754)
2	Сонгуулийн өгсөн хүний тоо	26,914	31,938	
3	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо	1	1	-
4	Түүнд ажиллах хүний тоо /нэг хэсэгт ажиллах хүний тоо	9	9	-
5	Сум, дүүргийн сонгуулийн хороо	18	18	-
6	Түүнд ажиллах хүний тоо /нэг хэсэгт ажиллах хүний тоо	92	94	(2)
7	Санал авах хэсгийн тоо	91	89	2
8	Сонгуулийн хороо, санал авах хэсэгт ажиллах нийт хүний тоо	630	645	(15)
9	Мэдээлэл технологийн баг	1	1	-

10	Мэдээлэл технологийн багт ажиллах нийт хүний тоо	5	5	-
11	МТ-ийн багийн даамлын тоо	110	113	(3)
12	Сонгуулийн нийт зардал /сая.төгрөг/	460.70	588.50	(127.80)

Сонгуулийн насны хүн амын тооны өсөлт, мэдээлэл технологийн баг, ажиллах хүч, бүрэлдэхүүний тоо өссөн үзүүлэлттэй байна.


2021 оны ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах зардлыг өмнөх сонгуулийн зардлын гүйцэтгэл, санал өгөх насны иргэд, ажиллах хүч, сонгуульд өрсөлдөх намуудын тоо зэргийг харьцуулан 588.5 сая төгрөг төлөвлөсөн нь 2017 оны батлагдсан төсвөөс 127.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь "МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардал"-ын хуваарилалтыг хийхдээ СЕХ-оос өгсөн чиглэл, тооцооллыг баримтлан сумдын Сонгуулийн хороонд 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 05 тоот албан бичгээр 1 дүгээр санхүүжилт, 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 10 тоот албан бичгээр 2 дугаар санхүүжилт, 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 37 тоот албан бичгээр 3 дахь хэсгийн санхүүжилтийг олгосон байна.

Мэдээлэл технологийн баг, даамлын сургалтын зардал нь танхимаар зохион байгуулахаар тооцоолсон боловч, цаг үеийн нөхцөлөөс шалтгаалан эхний удаад онлайнаар сургалтыг хийж даамлуудад нэгж, дата олгож, сумдад шатахуун болон томилолтын зардлыг хуваарилаагүй байна.

Аймгийн Сонгуулийн хороо, СЕХ-оос өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу 19 сумын хэсгийн хороодод хуваарилсан 588.5 сая төгрөгийг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График №4 /сая төгрөг/



Зарим Сонгуулийн хороонд цаг үеийн нөхцөл байдал хүндэрч бороо хур их орсноос шалтгаалан голын усны түвшин нэмэгдсэн тул, туулах чадвар сайтай машинаар сонгогчдыг аюулгүй гатлуулах арга хэмжээ авч сонгуулийн үйл ажиллагааг хэвийн явуулахад нэмэлт зардлын хэрэгцээ үүссэн тул, аймгийн СХ-нд хүсэлт тавьж нийт 3.8 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

- ✓ Биндэр сум 1.1 сая төгрөг
- ✓ Батширээт сум 0.5 сая төгрөг
- ✓ Дадал сум 1.6 сая төгрөг
- ✓ Өмнөдэлгэр сум 0.6 сая төгрөг

✓ БҮЛЭГ 2: МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛААС 3.6 СЯА ТӨГРӨГИЙГ ХЭМНЭХ БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ БАЙНА.

2.1 Сонгуулийн хороо нь УИХ болон ОН-ийн сонгуулиар авсан далбааг Ерөнхийлөгчийн сонгуулиар дахин ашиглаж 3.6 сая төгрөг хэмнэх боломжийг ашиглаагүй байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо батлагдсан төсвийн 98.6 хувь буюу 580.6 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл ажилтнуудын мөнгөн урамшуулал, хоолны зардалд 409.6 сая төгрөг буюу 70.5 хувь, унаа болон тээврийн зардалд 69.6 сая төгрөг буюу 12.0 хувь, санал авах байр бэлтгэх, тохижуулах зардалд 28.3 сая төгрөг буюу 4.9 хувь, шуудан холбоо, бичиг хэргийн зардалд 31.1 сая төгрөг буюу 5.4 хувь, болзошгүй зардалд 10.1 сая төгрөг буюу 1.7 хувийг зарцуулсан байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7.1.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Сонгуулийн хорооноос аймаг, сумдын сонгуулийн хороодод 588.5 сая төгрөгийг хуваарилж, аймаг, сумдын Сонгуулийн хороо нь СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" тухай журам"-ын 3.9-т заасны дагуу зарцуулагдаагүй үлдэгдэл 7.9 сая төгрөгийг холбогдох дансанд буцаан төвлөрүүлжээ.

Санал авах байрыг гэрэлтүүлэх, эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай болон цахилгаан тасарсан үед ашиглах мотор түрээслэх зориулалтаар нийт 4.0 сая төгрөг хуваарилагдсанаас 3.4 сая төгрөгийг сумдад хуваарилж үлдэгдэл 0.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт №3 /сая төгрөг/

Д/д	Зардлын нэр	Хэнтий аймгийн СХ	Мөрөн сум	Дэлгэрхаан сум	Батширээт сум	Баянхутаг сум	Цэнхэрмандал сум	Дархан сум	Нийт
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	0.1							0.10
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	0.4							0.40

3	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал		0.01	0.01	-	-	-	0.17	0.19	
4	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарсан зардал	Сургалтын зардал	2.8						2.80	
		Мэдээ дамжуулах унааны зардал	0.1	0.00	0.11	0.12	0.02	-	-	0.34
		Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	0.6	-	0.00	0.02	0.13	-	0.06	0.80
5	Бичиг хэргийн зардал		0.02	-	-	-	-	-	0.02	
6	Унааны зардал		0.09	0.50	0.51	0.35	0.10	-	1.55	
7	Албан томилолтын зардал		0.00	0.00	0.00	0.02	-	-	0.02	
8	Болзошгүй зардал	1.2	-	-	0.50	-	-	-	1.70	
НИЙТ ДҮН			5.20	0.12	0.62	1.14	0.51	0.10	0.23	7.93

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороо болон сонгууль зохион байгуулахад тодорхой чиг үүргийн дагуу оролцдог УБХэлтэс, Цагдаагийн газарт дээд түвшний байгууллагуудаас нь нийт 92.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, бүрэн зарцуулж дараах байдалтай байна.

Хүснэгт №4 /сая төгрөг/

Үзүүлэлт	Цагдаагийн газар			УБХэлтэс			Нийт		
	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Урамшууллын зардал			-	49.6	49.8	-0.2	49.6	49.8	-0.2
Томилолт, унааны зардал			-	16.6	14.4	2.2	16.6	14.4	2.2
Шуудан холбооны зардал	3.2	3.2	-			0	3.2	3.2	0
Шатахууны зардал	1.0	1.0	-	3.2	4.1	-0.9	4.2	5.1	-0.9
Хоолны зардал	11.3	11.3	-			0	11.3	11.3	0
Бичиг хэргийн зардал			-	5.5	5.4	0.1	5.5	5.4	0.1
Сургалтын зардал			-	1.8	3.0	-1.2	1.8	3	-1.2
Нийт дүн	15.5	15.5	-	76.7	76.7	0.0	92.2	92.2	0.0

Нийт олгосон санхүүжилтээс 49.6 сая төгрөгийг ажилтны урамшууллын зардалд 16.6 сая төгрөгийг албан томилолт, унааны зардалд, 3.2 сая төгрөгийг шуудан холбооны зардалд, 4.2 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 11.3 сая төгрөгийг хоолны зардалд, 5.5 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд, 1.8 сая төгрөгийг сургалтын зардалд тус тус зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

- Сонгуулийн хороо нь УИХ, Орон нутгийн сонгуулиар авсан туг, далбааг Ерөнхийлөгчийн сонгуулиар ашиглахгүй худалдан авахаар дахин төлөвлөн 3.6 сая төгрөг зарцуулсан нь төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулж байна.

-УБХэлтэс 2.2 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Иймд дараагийн сонгуулиар холбогдох журам, зөвлөмжийг мөрдөж зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байхад анхаарч хариуцлагын тогтолцоог бий болгох нь зүйтэй.

2.2 Батлагдсан төсвөөс 0.2 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн тайлагнасан байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд 588.5 сая төгрөгийн төсөв хуваарилагдаж 580.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 2.7 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн Сонгуулийн хороонд төвлөрүүлжээ.

Норовлин сумын Сонгуулийн хороо нь урамшуулал, хоолны зардлаас 150.0 мянга, бичиг хэргийн зардлаас 50.0 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулж сургалтын зардалд тайлагнаснаас бусад Сонгуулийн хэсгийн хороо нь төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан байна.

Хүснэгт №5 /сая төгрөг/

Д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	0.3	0.1	0.1	
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	19.0	18.6	0.4	
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарсан зардал	Сургалтын зардал	16.1	13.3	2.8
		Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	4.0	3.2	0.8
4	Дүн мэдээ дамжуулах зардал	5.3	4.9	0.4	
5	Санал авах байр тохижуулах зардал	28.5	28.3	0.2	
6	Сургалт, сурталчилгааны зардал	5.0	5.0	-	
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	409.6	409.6	-	
8	Бичиг хэргийн зардал	14.0	14.0	0.0	
9	Шуудан холбооны зардал	17.1	17.1	-	
10	Унааны зардал	52.6	51.0	1.6	
11	Албан томилолтын зардал	5.5	5.5	0.0	
12	Болзошгүй зардал	11.8	10.1	1.7	
Нийт дүн		588.6	580.6	8.0	

2.3 Засгийн газрын нөөц сангаас 39.0 сая төгрөгийн халдваргүйтгэлийн хэрэгсэл олгосон байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын нөөц сангаас Хэнтий аймгийн Онцгой байдлын газарт санитал 601 ширхэг, амны хаалт 62269 ширхэг, бээлий 5300 ширхэг, жавилин 2670 ширхэг, нүүрний хаалт 267 ширхэг, хамгаалалтын хувцас 356 ширхэг буюу нийт 39.0 сая төгрөгийн ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгсэл хүлээлгэн өгснийг 18 дугаар тойргийн 89 хэсэгт хуваарилан олгосон байна.

Хүснэгт №6

Д/д	Сумын нэр	Сонгогчийн тоо	Ажилтны тоо	Нэг удаагийн амны хаалт	Нэг удаагийн резин бээлий	Нүүрний хаалт	Хамгаалтын хувцас	Санитол	Ариутгалын бодис
		тоо	тоо	Ш	ХОС	Ш	Ш	л	л
1	Өмнөдэлгэр	3,883	89	4733	420	21	28	47	210
2	Батширээт	1,641	53	2141	240	12	16	24	120
3	Биндэр	2,762	65	3362	290	15	20	30	150
4	Баян-Адарга	1,695	53	2195	240	12	16	24	120
5	Баянхутаг	1,677	41	2077	190	9	12	23	90
6	Галшар	1,462	65	2062	290	15	20	25	150
7	Бор-Өндөр	5,552	67	6172	300	15	20	50	150
8	Дархан	1,326	53	1826	240	12	16	24	120
9	Баянмөнх	1,100	53	1600	240	12	16	24	120
10	Батноров	3,743	79	4493	350	18	24	46	180
11	Баян-Овоо	1,254	53	1754	240	12	16	24	120
12	Норовлин	1,752	53	2252	240	12	16	24	120
13	Дадал	2,057	53	2557	240	12	16	24	120
14	Мөрөн	1,337	53	1837	240	12	16	24	120
15	Дэлгэрхаан	1,492	65	2092	290	15	20	25	150
16	Жаргалтхаан	1,648	65	2248	290	15	20	25	150
17	Цэнхэрмандал	1,468	53	1968	240	12	16	24	120
18	Хэрлэн	15,341	171	16900	720	36	48	114	360
Нийт дүн		51,190	1,184	62269	5300	267	356	601	2670

Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахад зориулж, Засаг даргын нөөц сангаас зардал гараагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд Хэнтий аймагт санал хураалтад ОБЕГазраас аймгийн Сонгуулийн хороонд 51190 иргэнээр тооцож амны хаалт олгосон бол 31,938 сонгогч саналаа өгсөн нь үлдэгдэл 5.7 сая төгрөгийн 19000 ширхэг амны хаалтыг буцаан төвлөрүүлээгүй байна.

2.4 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын 8.6 хувь буюу 50.2 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн хороо, 91.4 хувь буюу 530.4 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороод зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо шатахууны зарцуулалтын баримт байхгүй, нэг удаагийн бээлийг сумдын хэсгийн хороодод хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй, зарцуулаагүй үлдэгдэл нэг удаагийн амны хаалтыг буцаан татаж аваагүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг дараагийн сонгуулиар давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь 6.6 сая төгрөгийн 37300 ширхэг нэг удаагийн бээлийг болзошгүй зардлаас худалдан авсан боловч, хэсгийн хороодод хүлээлгэн өгсөн акт, зарцуулалтын баримт, тайлан байхгүй байна.

- Аймгийн Сонгуулийн хорооны зарцуулсан 1.4 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас байхгүй, явсан зам маршрут тодорхойгүй шаардах хуудсаар зарлага гаргасан байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулахад Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль журам, зориулалтын дагуу хуваарилсан байна.
2. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлаас 3.6 сая төгрөгийг хэмнэх боломжийг ашиглаагүй байна.

Аудитын дүнгээс нийт 19.7 сая төгрөгийн зөрчил илэрснийг эс тооцвол "МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна" гэсэн нэгдсэн ДҮГНЭЛТ хийлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргад:

- ✚ Цаашид төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах.
- ✚ Зарим Сонгуулийн хэсгийн хороо нь хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх.
- ✚ Аймгийн Сонгуулийн хороо нь үнэ төлбөргүй олгож байгаа бараа материалыг актаар хүлээлгэн өгч, зарцуулалтын тайланг гаргуулж, хяналтыг сайжруулж ажиллах.
- ✚ Аймгийн Сонгуулийн хороо явах замын маршрут, хэмжээг нарийн тогтоосон зураглал бүхий баримт үйлдэх, анхан шатны баримтыг зохих заавар журмын дагуу үйлдэж шатахууны тайланг гаргаж байх.

Хэнтий аймгийн УБХэлтэст:

- ✚ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллагад албан ёсоор хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх.

Уламжлах санал:

- ✚ Аймаг, сумдын СХ-ны бараа материалын зарцуулалтын тооцоонд ашиглах анхан шатны баримтууд, тооцооллыг хэрхэн хийх, тайлан гаргах зэргийг нэгдсэн арга зүйгээр хангах арга хэмжээг зохион байгуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн санал	Саналд өгсөн тайлбар
<p style="text-align: center;"> ХЭНТИЙ АЙМАГ СОНГУУЛИЙН ХОРОО Хүнлэгийн 17, Хэнтий аймаг Увс сум, 15100-2411</p> <p style="text-align: center;">2011.02.08</p> <p style="text-align: center;">ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Ж ГАНБААТАР</p> <p style="text-align: right;"><i>Жансүрэн М. Дорноо</i> <i>Анхбаяр</i> <i>2011.02.08</i></p>	<p>Аймгийн Сонгуулийн хороо тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.</p>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 07 дугаар сарын 06

Дугаар А/10

Чингис хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын хуулийн хүрээнд хийгдэж буй Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газрын гуравдугаар газар, аймгийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор /Ц.Нарангэрэл/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан
Хэнтий аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл**

Д/д	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн насны хүний тоо		Сонгуулийн өгсөн хүний тоо		Хэсгийн хорооны тоо		Зардлын төсөв /сая төгрөг/		Гүйцэтгэл /сая төгрөг/		Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/	
		2017	2021	2017	2021	2017	2021	2017	2021	2017	2021	2017	2021
1	Хэнтий аймгийн Сонгуулийн хороо								124.6	116.8	50.2	7.8	5.2
2	Хэрлэн сумын Сонгуулийн хороо	14164	14905	7569	8638	12	12	40.3	73.3	40.2	73.3	0.1	0
3	Батноров сумын Сонгуулийн хороо	3471	3681	2066	2523	7	6	24.4	34.9	24.4	34.9	0	0
4	Батширээт сумын Сонгуулийн хороо	1544	1618	865	1053	4	4	15.5	24.7	15.5	23.6	0	1.1
5	Баян-Адарга сумын Сонгуулийн хороо	1535	1663	1041	1174	4	4	15.2	24.2	15.2	24.2	0	0
6	Баянмөнх сумын Сонгуулийн хороо	1001	1080	653	766	4	4	15.1	24.1	15.1	24.1	0	0
7	Баян-Овоо сумын Сонгуулийн хороо	1078	1234	707	949	4	4	15.1	24.2	15.1	24.2	0	0
8	Баянхутаг сумын Сонгуулийн хороо	1485	1644	756	974	3	3	11.5	19.1	11.3	18.5	0.2	0.6
9	Биндэр сумын Сонгуулийн хороо	2585	2732	1535	1801	5	5	19.3	30.3	19.3	30.3	0	0
10	Галшар сумын Сонгуулийн хороо	1401	1437	879	919	6	5	21.6	29.1	21.6	29.1	0	0
11	Дадал сумын Сонгуулийн хороо	1798	2016	985	1367	4	4	17.2	25.9	17.2	25.9	0	0
12	Дархан сумын Сонгуулийн хороо	1253	1309	708	875	4	4	15.3	24.0	15.0	23.8	0.3	0.2
13	Дэлгэрхаан сумын Сонгуулийн хороо	1569	1702	1055	1225	4	5	14.6	28.9	14.2	28.3	0.4	0.6
14	Жаргалтхаан сумын Сонгуулийн хороо	1361	1454	1013	1056	5	5	18.1	28.9	18.1	28.9	0	0
15	Мөрөн сумын Сонгуулийн хороо	1288	1309	745	874	5	4	17.6	24.0	17.6	23.9	0	0.1
16	Норовлин сумын Сонгуулийн хороо	1506	1737	935	1141	4	4	16.0	24.2	16.0	24.2	0	0
17	Өмнөдэлгэр сумын Сонгуулийн хороо	3653	3798	2030	2263	7	7	24.4	39.5	24.4	39.5	0	0
18	Цэнхэрмандал сумын Сонгуулийн хороо	1329	1437	862	987	4	4	15.3	24.0	15.3	23.9	0	0.1
19	Бор-Өндөр сумын Сонгуулийн хороо	5345	5364	2510	3353	5	5	19.6	29.8	19.6	29.8	0	0
	Хэнтий дүн	47366	50120	26914	31938	91	89	460.7	588.5	451.9	580.6	8.8	7.9

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан Хэнтий аймгийн сонгуулийн хорооны удирдах албан тушаалтаны талаарх судалгаа

Д/д	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн хорооны дарга					Сонгуулийн хорооны нягтлан бодогч				
		Овог, нэр	Регистрийн дугаар	Томилогдсон албан тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхэлж буй албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Томилогдсон албан тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхэлж буй албан тушаал
1	Хэнтий аймгийн Сонгуулийн хороо	Жигжид Ганбаатар	СИ71012611	2021.03.29 №40	Эрх зүйч	Аймгийн ЗДТГ-ын дарга	Гүрцэдэн Ариунхүү	СД86031003	2021.04.09 №02	Нягтлан бодогч	Ажилгүй
2	Хэрлэн сумын Сонгуулийн хороо	Гүрбадам Болд	СМ74040515	2021.04.07 №02	Төрийн удирдлага	Сумын ЗДТГ-ын дарга	Довжоо Баттунгалаг	ЦГ70051505	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Татварын хэлтэст хэлтсийн дарга
3	Батноров сумын Сонгуулийн хороо	Маналжав Ган-эрдэнэ	СА69100310	2021.04.07 №02	Үйлдвэр үйлчилгээний менежер	Сумын ЗДТГ-ын дарга	Лувсанжамц Амармэнд	СА89021219	2021.04.07 №02	Бизнесийн удирдлага	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
4	Батширээт сумын Сонгуулийн хороо	Бадам Эрдэнэчимэг	ЕЭ69082761	2021.04.07 №02	Төрийн удирдлагын менежер	Сумын ЗДТГ-ын дарга	Намсрай Одончимэг	СБ76041005	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
5	Баян-Адарга сумын Сонгуулийн хороо	Оюунчимэг Баттогтох	СВ85102214	2021.04.07 №02	Гадаад худалдаа гаалийн менежер	Сумын ЗДТГ-ын дарга	Батдэлгэрэх Агиймаа	СЮ93102403	2021.04.07 №02	Даатгалын эдийн засагч	Нягтлан бодогч
6	Баянмөнх сумын Сонгуулийн хороо	Амгалан Болормаа	СГ86082209	2021.04.07 №02	Хүнсний хими, технологич	Сумын ЗДТГ-ын дарга	Володъя Болортуяа	СГ80040707	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
7	Баян-Овоо сумын Сонгуулийн хороо	Борной Сарантуяа	ЧМ65092820	2021.04.07 №02	Багш	Сумын ЗДТГ-ын дарга	Төмөрхуяг Эрдэнэцэцэг	СД87091207	2021.04.07 №02	Эдийн засгийн математик загварчлал	ХАА тасгийн мэргэжилтэн
8	Баянхулаг сумын Сонгуулийн хороо	Баарсайхан Золбоо	СЭ87060271	2021.04.07 №02	Үйлдвэрлэлийн орчин зүйн инженер	Сумын ЗДТГ-ын дарга	Жаргалсайхан Бямбасүрэн	СЮ93112001	2021.04.07 №02	Татвар, эдийн засаг, нягтлан бодогч	Нягтлан бодогч
9	Биндэр сумын Сонгуулийн хороо	Ганзориг Өнөболд	СЖ89012416	2021.04.07 №02	Үйлвэрлэлийн менежер, Агрономич	Сумын ЗДТГ-ын дарга	Ган-Эрдэнэ Бат-Эрдэнэ	СЖ88122414	2021.04.07 №02	Банк санхүү нягтлан бодогч	Нягтлан бодогч
10	Галшар сумын Сонгуулийн хороо	Шагдар Цэвэлсүрэн	СИ70040409	2021.04.07 №02	Эрх зүйч	Сумын ЗДТГ-ын дарга	Мягмар Мөнх-Од	СИ75111107	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
11	Дадал сумын Сонгуулийн хороо	Дамбарчинчиг Гэрэлмаа	СП84102801	2021.04.07 №02	Инженер, төрийн удирдлагын менежер	Сумын ЗДТГ-ын дарга	Санжаа Тэмүүлэн	СИ72050301	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Татварын улсын байцаагч

12	Дархан сумын Сонгуулийн хороо	Шархуу Отгонжаргал	СК84090918	2021.04.07 №02	Төрийн захиргаа удирдлага	Сумын ЗДТГ-ын дарга	Наранцэцэг Номинчулуун	СК88111705	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
13	Дэлгэрхаан сумын Сонгуулийн хороо	Занаа Ганбаатар	СЛ61050216	2021.04.07 №02	Төрийн удирдлага	Сумын ЗДТГ-ын дарга	Датвабүслүүр Соёлмаа	СЮ73032565	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
14	Жаргалхаан сумын Сонгуулийн хороо	Гүрдорж Мөнхсайхан	СМ85041718	2021.04.07 №02	Газрын кадастрын инженер	Сумын ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Наранцэцэг Энхзул	СЭ83032005	2021.04.07 №02	Нягтлан бодогч	ЗДТГ-ын бичиг хэргийн эрхлэгч
15	Мөрөн сумын Сонгуулийн хороо	Норовсүрэн Намжилноров	СО71030519	2021.04.07 №02	Төрийн захиргааны удирдлага	Сумын ЗДТГ-ын дарга	Дамдин Эрдэнэцэцэг	СО75030709	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Санхүүгийн албаны дарга
16	Норовлин сумын Сонгуулийн хороо	Бямбасүрэн Наранбаяр	СЖ70072976	2021.04.07 №02	Багш	Сумын ЗДТГ-ын дарга	Пүрэв Батгэрэл	СП79070304	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Татварын улсын байцаагч
17	Өмнөдэлгэр сумын Сонгуулийн хороо	Лувсандорж Баярмаа	СР78012801	2021.04.07 №02	Улс төр судлаач, улс төр, нийгэм судлалын багш	Сумын ЗДТГ-ын дарга	Баатарсайхан Гантулга	СР88080612	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нягтлан бодогч
18	Цэнхэрмандал сумын Сонгуулийн хороо	Үржинбазар Ичинхорлоо	СУ86092288	2021.04.07 №02	Багш	Сумын ЗДТГ-ын дарга	Адилбиш Гансүх	СЖ72101226	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нийгмийн даатгалын байцаагч
19	Бор-Өндөр сумын Сонгуулийн хороо	Зерынов Ууганжаргал	СЦ80031016	2021.04.07 №02	Эрх зүйч	Сумын ЗДТГ-ын дарга	Машбат Өлзийсайхан	УУ81032624	2021.04.07 №02	Нягтлан бодогч	Нярав

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 3
дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

2021 он

/төгрөгөөр/

Д/д	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	250,000	146,000	104,000
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	19,018,000	18,615,035	402,965
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарсан зардал	Сургалтын зардал	13,283,400	2,796,600
		Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,217,180	787,820
4	Дүн мэдээ дамжуулах зардал	5,300,000	4,893,432	406,568
5	Санал авах байр тохижуулах зардал	28,480,000	28,285,350	194,650
6	Сургалт, сурталчилгааны зардал	5,000,000	5,000,000	-
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	409,580,000	409,580,000	-
8	Бичиг хэргийн зардал	14,010,000	13,981,300	28,700
9	Шуудан холбооны зардал	17,050,000	17,050,000	-
10	Унааны зардал	52,550,000	50,994,304	1,555,696
11	Албан томилолтын зардал	5,482,000	5,460,730	21,270
12	Болзошгүй зардал	11,752,000	10,071,900	1,680,100
Нийт дүн		588,557,000	580,578,631	7,978,369

Аймгийн нэр: ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн аудитын байгууллагаас хийсэн гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021-07-02 **АУДИТЫН КОД:** ХЭА-47-22-ЦТА-СА **Аудитын код:** "МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ" -Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шалгагдсан **Хэнтий аймгийн Сонгуулийн хороо, УБХэлтэс, Цэвдэвгийн гзар, ОБГзар** **Сая төгрөгөөр**

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагын гаргасан шийдэл			Алдаа зөрчилтэй асуудал гаргасан байгууллага албан тушаалтан		
					Нэр	Огноо	Дугаар	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог, нэр
1		2	3	4	5	6	7	8	9	10
1	А.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан уу?	1	Сонгуулийн хороо нь УИХ, Орон нутгийн сонгуулиар авсан туг, далбааг Ерөнхийлөгчийн сонгуулиар ашиглахгүй худалдан авахаар дахин төлөвлөн 3.6 сая төгрөг зарцуулсан нь төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг мөрдөөгүй байна.	3.6	Зөвлөмж өгөх	2021.07.02		Хэнтий аймгийн Сонгуулийн хороо	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганбаатар, Г.Ариунхүү
		1	УБХэлтэс 2.2 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан нь, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг мөрдөөгүй байна.	2.2	Зөвлөмж өгөх	2021.07.02		Хэнтий аймгийн УБХэлтэс	Дарга, нягтлан бодогч	Б.Төрхүү, Б.Ганцэцэг

2	А.2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?	1	<p>Норовлин сумын Сонгуулийн хороо нь урамшуулал, хоолны зардлаас 150.0 мянга, бичиг хэргийн зардлаас 50.0 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулж сургалтын зардалд тайлагнасан нь, СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.8-д "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.</p>	0.2	Зөвлөмж өгөх	2021.07.02	Хэнтий аймгийн Норовлин сумын Сонгуулийн хороо	Дарга, нягтлан бодогч	Н.Лхагва, П.Батгэрэл
3	А.2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан уу?	1	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд Хэнтий аймагт санал хураалтад ОБЕГ газраас аймгийн Сонгуулийн хороонд 51190 иргэнээр тооцож амны хаалт олгосон бол 31,938 сонгогч саналаа өгсөн нь үлдэгдэл 5.7 сая төгрөгийн 19000 ширхэг амны хаалтыг буцаан төвлөрүүлээгүй байна. Энэ нь СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6-д Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна</p>	5.7	Зөвлөмж өгөх	2021.07.02	Хэнтий аймгийн Сонгуулийн хороо	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганбаатар, Г.Ариунхүү

4	<p>A.2.4. Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнтэй байна уу?</p>	<p>1</p> <p>МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь 6.6 сая төгрөгийн 37300 ширхэг нэг удаагийн бээлийг болзошгүй зардлаас худалдан авсан боловч, хэсгийн хороодод хүлээлгэн өгсөн акт, зарцуулалтын баримт, тайлан байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.</p>	6.6	Зөвлөмж өгөх	2021.07.02	Хэнтий аймгийн Сонгуулийн хороо	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганбаатар, Г.Ариунхүү
	<p>1</p> <p>Аймгийн Сонгуулийн хорооны зарцуулсан 1.4 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас байхгүй, явсан зам маршрут тодорхойгүй шаардах хуудсаар зарлага гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.</p>	1.4	Зөвлөмж өгөх	2021.07.02	Хэнтий аймгийн Сонгуулийн хороо	Дарга, нягтлан бодогч	Ж.Ганбаатар, Г.Ариунхүү	
	6	19.7						